



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/445

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр биелүүлэн  
захирамжийн холбогдох заалтыг хүчингүй  
болгож, эрх сэргээх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 128/ШШ2020/0736 дугаар захирамж, 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Эвлэрлийн гэрээ”, Дүүргийн “Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл”-ийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эвлэрлийн гэрээ”-нд тусгагдсан “Алтан эрдэнэ консалтинг” ХХК-ийн үйлдсэн кадастрын зургийн координатын дагуу “Гүнгэрваа” ХХК-д 2043 м<sup>2</sup> газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилээр, иргэн П.Ганзоригт хоёр нэгж талбарыг нэгтгэн “Алтан эрдэнэ консалтинг” ХХК-ийн үйлдсэн кадастрын зургийн координатын дагуу 1732 м<sup>2</sup> газрыг аж ахуйн зориулалтаар 15 жилээр тус тус баталгаажуулан газар эзэмших эрх олгосугай.

2. Баянгол дүүргийн 20 дугаар хороонд Дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/202 дугаар захирамжийн иргэн П.Ганзоригт холбогдох хэсгүүдийг тус тус хүчингүй болгосугай.

3. Үүнтэй холбогдуулан “Гүнгэрваа” ХХК, иргэн П.Ганзориг нарт холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, газрын улсын бүртгэлд бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалтын алба (Д.Энхтөр)-нд даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР